



Монгол-Германы эдийн засгийн клуб



Хоёр орны найрамдалт харилцаа,
эдийн засгийн хамтын ажиллагаанд
хувь нэмрээ оруулагч, сонирхогч,
нийгэмлэг, байгууллага хувь хүн
бүхэнд нээлттэй
тулах цэг, амжилтын үндэс
болох гарааны шугам,
мэдээлэл солилцооны
хамтын орон зай



Эрхэм зорилго, үйл ажиллагаа

Монгол-Германы Эдийн засгийн клуб (MDWK) нь «Хоёр орны найрамдалт харилцааны үйл хэрэгт хувь нэмэр оруулах, эдийн засгийн харилцан хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах, хоёр орны бизнес эрхлэгчид харилцан харилцаа холбоо тогтоох, бизнесийн түнш, хамтрагчаа олоход дэмжлэг болох» үйл ажиллагааны чиглэл бүхий ХБНГУ-д албан ёсны бүртгэл, үйл ажиллагаа явуулах эрхтэй байгууллага юм.

MDWK –нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд хоёр орны холбогдох яам, тамгын газрууд, дипломат төлөөлөгчдийн газруудтай болон ХБНГУ-ын муж улсуудын төлөөлөлүүд, үйлдвэрлэл эрхлэгчид, эдийн засгийн бусад холбоо нийгэмлэгүүдтэй холбоо харилцаа үүсгэн ажилладаг төдийгүй хоёр оронд өөрийн клуб, дэмжигчдийн сүлжээг хэдийн үүсгэн байгуулсан байна.

Клубээс тогтмол зохион явуулдаг эдийн засгийн өдөрлөг, бизнес уулзалт нь гишүүд дэмжигч, хамтрагчид харилцан туршлага, боломж, санаа оноогоо солилцох боломж үүсгэдэг төдийгүй хэрэгцээт мэдээлэлийг шууд болон шуурхай орж авах эх үүсвэр болдгоороо онцлогтой.

Манай клубын гишүүдийн дийлэнх нь жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч, хувиараа аж ахуй эрхлэгч нараас бүрддэг ба бидний үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллахыг санал болгож буй хэн бүхэнд клубын зүгээс нээлттэй, талархан хүлээн авах болно.





ХБНГУ-тай харилцан үр ашигтай хамтын ажиллагаа үүсгэх

тулгын гурван шалтгаан ...



Хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өнөөдөр цоо шинэ үе шатад ирээд байгаа ба ард түмнүүдийн хоорондын харилцааг түүхийн үүднээс хөөж үзвэл хэдэн зууны тэртээд хамрагдах бөлгөө. Боловсрол, шинжлэх ухааны салбарт 1920 оны үеэс монгол оюутнууд Германд суралцаж эхэлсэн ба түүнээс хойш олон мянган залуучууд суралцаж, мэргэжил дээшлүүлж ирсэн байна.



Эдийн засгийн чиг хандлага

Манай оронд үйлдвэрлэл хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг бий болгох тулгуур үндэс нь дэлхийн зах зээлд, ялангуяа хэрэглэгчдийн худалдан авах чадвар өндөр Европын Холбооны улсуудад чиглэсэн бараа, бүтээгдээгдэхүүний урсгалыг эрчимжүүлэх шаардлага бүхий түүхийн цаг үе тохиож байна.



Шинэ санаа, жижиг дунд үйлдвэрлэгчдийн эрин үе

Үсрэнгүй хөгжил, өдөр бүх шинэчлэгдэж буй технологийн зуунд чанартай үйлдвэрлэл, техник технологийн эх орон болсон ХБНГУ-ын жижиг дунд үйлдвэрлэгч нартай найдвартай түншлэлийн шууд холбоо тогтоон, харилцан үр ашигтай хамтын ажиллагаа эхлүүлэн ажиллах нь таны амжилтын тулгуур болох болно.

Монгол-Германы эдийн засгийн клуб

Холбоо барих : <http://www.mdwk.info>